



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/42/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 261628 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Төгс нягт гурав аудит ХХК
Захирал: Д.Цэнд
Цахим хаяг: tsenddorjkhloroo@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Албан шаардлага	17
8.2 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын Хоёрдугаар Газар
БХӨТ	Богино Хугацаат Өр Төлбөр
ГОУХАН	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ДЭХ	Дулааны Эрчим Хүч
НА	Нотлох Ажил
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЗЭ	Тусгай Зөшөөрөл Эзэмшигч
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН
ТАНАА

2022.03.15 № 07/540
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 4,130.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,554.6 сая төгрөгөөр, алдагдлыг 424.2 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 4,487.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,795.0 сая төгрөгийн зардал гарган, 307.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд тус хороо нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхгүйгээр 4 орон тоог хэмнэж ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЦНАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	281,018,406.88	282,935,860.13
1.1.2	Дансны авлага	407,732,965.26	305,023,424.31
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	100,316,958.71	4,652,640.06
1.1.4	Бусад авлага	2,168,484.28	210,276.17
1.1.6	Бараа материал	11,237,188.50	16,591,773.67
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	151,549,180.50	7,200,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	954,023,184.13	616,613,974.34
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,752,743,569.39	4,613,817,825.90
1.2.2	Биет бус хөрөнгө	75,359,348.48	70,180,257.56
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,828,102,917.87	4,683,998,083.46
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,782,126,102.00	5,300,612,057.80
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	210,824.00	-
2.1.1.3	Татварын өр	-	21,237,189.06
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	158,331,998.44	10,158,490.73
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	158,542,822.44	31,395,679.79
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	434,669,194.93	387,899,607.17
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	434,669,194.93	387,899,607.17
	Өр төлбөрийн нийт дүн	593,212,017.37	419,295,286.96
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	104,537,450.95	104,537,450.95
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	61,916,617.76	61,916,617.76
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	35,618,000.00	35,618,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,986,842,015.92	4,679,244,702.13
	Эздийн өмчийн дүн	5,188,914,084.63	4,881,316,770.84
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,782,126,102.00	5,300,612,057.80

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,338,406,572.84	4,130,387,169.00
2	Борлуулалтын өртөг	4,096,735,785.26	4,144,134,195.07
3	Нийт ашиг (алдагдал)	241,670,787.58	(13,747,026.07)
4	Хүүний орлого	6,293,257.42	-
5	Бусад орлого	34,590,697.28	357,137,813.74
6	Ерөнхий ба удирдлагын зардал	523,821,389.87	354,728,740.72
7	Бусад зардал	1,372,356.94	296,099,225.32
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	243,147.77	(98,480.12)
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(242,395,856.76)	(307,535,658.49)
10	Орлогын татварын зардал	5,517,707.24	61,655.30
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(247,913,564.00)	(307,597,313.79)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(247,913,564.00)	(307,597,313.79)
13	Орлогын нийт дүн	(247,913,564.00)	(307,597,313.79)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	5,234,755,579.92	5,436,827,648.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	5,234,755,579.92	5,436,827,648.63
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(247,913,564.00)	(247,913,564.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	4,986,842,015.92	5,188,914,084.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	4,986,842,015.92	5,188,914,084.63
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(307,597,313.79)	(307,597,313.79)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	4,679,244,702.13	4,881,316,770.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,119,902,111.46	5,403,835,992.48
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,765,893,026.27	4,805,594,069.78
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	133,070,810.00	382,447,000.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	16,489,288.00	26,007,812.70
	Буцаан авсан албан татвар	-	22,107,652.24
	Бусад мөнгөн орлого	204,448,987.19	167,679,457.76
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,343,292,820.63	5,247,229,695.11
	Ажиллагчдад төлсөн	2,817,554,078.94	2,698,601,963.31
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	758,274,444.87	706,209,648.42
	Бараа материал худалдан авахад төлсөн	405,355,184.30	264,687,761.56
	Ашиглалтын зардалд төлсөн	66,318,823.12	76,641,336.18
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	102,650,481.42	76,770,914.10
	Татварын байгууллагад төлсөн	915,254,530.84	1,031,684,489.34
	Даатгалын төлбөрт төлсөн	10,955,940.00	70,036,139.65
	Бусад мөнгөн зарлага	266,929,337.14	322,597,442.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(223,390,709.17)	156,606,297.37
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,293,257.42	-
	Хүлээн авсан хүүний орлого	6,293,257.42	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	449,637,554.00	154,682,624.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	449,637,554.00	154,682,624.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(443,344,296.58)	(154,682,624.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү	243,147.77	(6,220.12)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(666,491,857.98)	1,917,453.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	947,510,264.86	281,018,406.88
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	281,018,406.88	282,935,860.13

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Нийт орлого	4,379,543.2	4,130,387.2	4,487,528.5	357,141.4
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	4,338,406.6	4,130,387.2	4,130,387.2	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	41,136.6	-	357,141.4	357,141.4
2	Нийт зардал	4,621,939.0	4,554,633.8	4,795,064.2	240,430.4
	Үүнээс:	-	-	-	-
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,096,735.8	4,198,986.3	4,144,134.2	(54,852.1)
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	523,821.4	355,647.5	354,728.7	(918.8)
	в) Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,381.9	-	296,201.3	296,201.3
3	Татварын өмнөх ашиг/алдагдал/	(242,395.8)	(424,246.6)	(307,535.7)	116,711.0
4	Цэвэр ашиг, алдагдал	(242,395.8)	(424,246.6)	(307,535.7)	116,711.0
5	Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.1	1.1	1.1	(0.0)
7	Нийт авлага	510,218.3	484,707.4	309,886.3	(174,821.1)
	Үүнээс: Зохицуулалтын үйлчилгээний хөлсний авлага	407,732.9	387,346.3	305,023.4	(82,322.8)
	Бусад авлага	102,485.4	97,361.2	4,862.9	(92,498.3)
8	Нийт өр төлбөр	593,212.0	563,551.4	419,295.3	(144,256.1)
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	158,542.8	563,551.4	31,395.7	(532,155.7)
9	Хөрөнгө оруулалт, их засвар	271.1	224,550.0	39,524.8	(185,025.2)
10	Нийт ажиллагсдын тоо	98	98	96	(2)
11	Нийт цалингийн сан	3,014,156.0	3,144,047.0	3,054,405.3	(89,641.7)
12	Ашигт ажиллагаа /ТӨАшиг/нийт хөрөнгө/	(41.92)	(80.04)	(58.02)	22.0
13	Төлбөрийн чадварын харьцаа/(Мх+Ав)/БХӨТ/	5.0	10	18.9	8.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны бүртгэл хөтлөлт, төрийн өмчийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Төгс нягт гурав аудит ХХК-ийн аудитор З.Тунгалаг, аудиторын туслах Ч.Билгүүнзаяа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Я.Пүрэвсүрэн, захирал Д.Цэнд нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын дотоод аудитын газар нь тайлант онд нийт 9 ажил хийхээр төлөвлөснөөс 8 ажил бүрэн хийгдсэн, 1 ажлын гүйцэтгэл 70 хувьтай, нийт ажлын гүйцэтгэл 96 хувьтай байна. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох ажлын хэсэг ажиллаж өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж тайлагнаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 4,627.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 92.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрчим хүчний зохицуулах хорооны зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай, 100 хувь төрийн өмчит байгууллага юм.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрчим хүчний зохицуулах хороог Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Эрчим хүчний зохицуулах хороо нь орон тооны гурав, орон тооны бус /Худалдаа аж үйлдвэр болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах/ хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдах ба зохицуулагчдыг Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтын дагуу Ерөнхий сайд томилдог байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийг Засгийн газрын 2016 оны 132 дугаар тогтоолоор баталсан, Хорооны эрх зүйн байдал, үйл ажиллагааны зохион байгуулалтыг энэ дүрмээр зохицуулдаг байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 307 дугаар тушаалыг үндэслэн Хорооны газар эзэмших эрхийг үнэлж нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн, мөн ТӨБЗГ-ын 2018 оны 86 тоот тогтоолыг үндэслэн

Хорооны өмч хамгаалах зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2021 оны 10 дугаар сард эрх бүхий байгууллагаар дүгнүүлэн, хангалттай үнэлгээ авч, 2021/УБ/28-0834 дугаар бүхий гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөхгүйгээр 4 орон тоог хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Хорооны захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээг аудитын зөвлөмжийн дагуу сургалтын төлбөртэй холбоотой заалтыг хасаж, салбарын хамтын хэлэлцээрт орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж баталсан;
- “Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын журам”-ыг Хорооны 2021 оны 423 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрчим хүчний зохицуулах хорооны тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	281,018.4	282,935.9	1,917.5
Авлага	510,218.4	309,886.3	(200,332.1)
Урьдчилгаа	151,549.2	7,200.0	(144,349.2)
Бараа материал	11,237.2	16,591.8	5,354.6
Үндсэн хөрөнгө	4,752,743.6	4,613,817.8	(138,925.8)
Биет бус хөрөнгө	75,359.3	70,180.2	(5,179.1)
Нийт хөрөнгийн дүн	5,782,126.1	5,300,612.1	(481,514.0)
Өр төлбөрийн дүн	593,212.0	419,295.3	(173,916.7)
Богино хугацаат өглөг	158,542.8	31,395.7	(127,147.1)
Урт хугацаат өглөг	434,669.2	387,899.6	(46,769.6)
Эздийн өмч	5,188,914.1	4,881,316.8	(307,597.3)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	5,782,126.1	5,300,612.1	(481,514.0)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд жижиг мөнгөн сан хэлбэрээр нийт 19.7 сая төгрөгийн орлого харилцахаас бүрдүүлж, 21.6 сая төгрөгийг зарцуулж, 1.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банкин дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд нийт 5,505.2 сая төгрөгийн орлого орж, 5,501.3 сая төгрөгийг зарцуулж, 281.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Худалдаа хөгжлийн банкны валют /доллар/-ын дансанд дахь 6.0 сая төгрөгийг төгрөгийн харилцах руу шилжүүлж долларын дансыг хаажээ.

Авлага дансны үлдэгдэл 309.9 сая төгрөг болж, 200.3 сая төгрөгөөр буурсан нь зохицуулалтын үйлчилгээний хөлсний авлага 102.7 сая төгрөгөөр, татварын илүү төлөлт буюу авлага 95.7 сая төгрөгөөр, бусад авлага 2.0 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2015-2017 онуудад үүссэн, он удаан жил болсон 106.4 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Нийт авлагаас 1 байгууллага /Зэт Ти Эм Эн Жи ХХК/-аас авах барагдах боломжгүй эрсдэлтэй 29.6 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Хорооны 2016 оны 60 тоот тогтоолоор Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөөгүй байна. Эрчим хүчний зохицуулах хороо нь тус тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзнийг эрэн сурвалжлахаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн газарт хандсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16.6 сая төгрөг болж, 5.3 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой бараа материалын хомсдолоос сэргийлж бичгийн цаас, принтерийн хор дараа оны эхний улиралд хэрэглэх хэмжээгээр нөөцөлснөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй, хуримтлуулсан бараа материал байхгүй байна.

Оны эцэст 5.3 сая төгрөгийн бичгийн цаас, принтерийн хорны худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Бараа материалын дансанд хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгө бүртгэгдээгүй байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь нийт 239.7 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч, 378.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ.

ТӨБЗГ-ын 2020 оны 664 тогтоолоор 103.8 сая төгрөгийн хөрөнгө, мөн газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад ТӨБЗГ-аас зөвшөөрөл авах шаардлагагүй” гэж заасны дагуу 75.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны А-1/576 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй нийт 59.7 сая төгрөгийн өртөгтэй 26 нэрийн хөрөнгийг акталж, 324.1 сая төгрөгийн хөрөнгөнд элэгдэл байгуулсан байна.

Биет бус хөрөнгө 5.2 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн хорогдол тооцоноос шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийг 127.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд хойшлогдсон орлого дансны үлдэгдэл 387.9 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн хойшлогдсон орлого дансанд НҮБ-ын сангийн НАМА төслийн 176.8 сая төгрөгийн тусламжийн хүрээнд хийгдсэн нарны үүсгүүрийн хандив тусламжийг НББОУС-20-ийн дагуу 18.0 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч, үлдэгдэл 146.0 сая төгрөг байна. Урт хугацаат өр төлбөрийн хойшлогдсон орлого дансанд ГОУХАН-ээс хэрэгжүүлж буй Эрчим хүчний үр ашиг 3+ төслийн 287.5 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн эрчим хүчний хэмнэлттэй барилгын хойшлогдсон орлогод 270.7 сая төгрөг, 2021 оны тайлант үеийн орлогоор 28.7 сая төгрөгийг бүртгэж, 241.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хуримтлагдсан үр дүн 4,881.3 сая төгрөг болж тайлант үеийн алдагдал 307.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад ерөнхий ба удирдлагын зардал 168.4 сая төгрөгөөр буурсан нь цалин нийгмийн даатгалын зардал, бараа ажил үйлчилгээ худалдан авах зардлыг хэмнэж ажилласантай холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3, Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйл /Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрх/-ийн 9.1.20-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг боловсруулж, хорооны хурлаар хэлэлцүүлэн, тогтоолоор батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2021 оны 12 дугаар тогтоолоор 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв, 13 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Хорооны 2021 оны 14 дүгээр тогтоолоор Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 4,073.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,554.6 сая төгрөгөөр тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 224.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 511, 665 дугаар тогтоолоор Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 онд Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 4,130.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Нийт орлого	4,379,543.2	4,130,387.2	4,487,528.6	357,141.4	108.6
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	4,338,406.6	4,130,387.2	4,130,387.2	-	100.0
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	41,136.6	-	357,141.4	357,141.4	-
2	Нийт зардал	4,621,939.1	4,554,633.8	4,795,064.2	240,430.4	105.3
	Үүнээс:	-	-	-	-	-
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,096,735.8	4,198,986.3	4,144,134.2	(54,852.1)	98.7
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	523,821.4	355,647.5	354,728.7	(918.8)	99.7
	в) Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,381.9	-	296,201.3	296,201.3	-
3	Цэвэр ашиг, алдагдал	(247,395.9)	(424,246.6)	(307,535.7)	116,710.9	72.5
4	Хөрөнгө оруулалт, их засвар	271.1	224,550.0	39,524.8	(185,025.2)	17.6

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 4,130.4 сая, туслах үйл ажиллагаанаас 357.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,795.0 сая төгрөгийн зарцуулж, 307.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс 116.7 сая төгрөгөөр алдагдлыг бууруулсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,487.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 357.1 сая төгрөг буюу 7.9 хувиар давсан нь Швейцарын хөгжлийн агентлагаас “Эрчим хүчний үр ашгийн шалгуур үзүүлэлт ба эрчим хүчний эрчимжилтийг тодорхойлох аргачлал” болон “Монгол улсын эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлын тоо хэмжээг түвшин бүрд тодорхойлох аргазүй”-г олон улсад ашигладаг аргачлалын дагуу үндэсний онцлогт тохируулан боловсруулах ажилд 264.9 сая төгрөг, ГОУХАН-ээс үзүүлэнгийн танхимын засал, тохижилтын ажилд 44.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн нь нийт орлого нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,795.0 сая төгрөгөөс үйл ажиллагааны зардалд 4,177.5 сая төгрөг зарцуулж, 323.4 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож, Швейцарын хөгжлийн агентлагаас “Эрчим хүчний үр ашгийн шалгуур үзүүлэлт ба эрчим хүчний эрчимжилтийг тодорхойлох аргачлал” болон “Монгол улсын эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлын тоо хэмжээг түвшин бүрд тодорхойлох аргазүй”-г олон улсад ашигладаг аргачлалын дагуу үндэсний онцлогт тохируулан боловсруулах ажилд 264.9 сая төгрөг болон ГОУХАН-ээс үзүүлэнгийн танхимын засал, тохижилтын ажилд 29.1 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 377.1 сая төгрөг буюу 8.3 хувиар хэмнэж ажиллажээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 9 нэр төрлийн 224.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 3 нэр төрлийн 39.5 сая төгрөгийн худалдан авалт хийж, ЗГ-ын 43 дугаар тогтоолтой холбогдуулан конторын тавилга эд хогшил зэрэг 185.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг дутуу гүйцэтгэсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд нийт 435 мэдээлэл байршуулахаас, 433 мэдээллийг хугацаандаа оруулж, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрчим хүчний зохицуулах хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д *“гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутамд худалдан авах ажиллагааны цахим системд оруулах”* гэж заасны дагуу мэдээллийг байршуулж, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Хорооны төсвийн зардлыг хэмнэх төлөвлөгөө гарган Хорооны 2021.03.19-ны өдрийн А/24 тоот тушаалаар 3 чиглэлийн 14 заалт бүхий бүхий төлөвлөгөө гаргаж ажилласнаар төсөвлөсөн нийт зардлыг 377.1 сая төгрөгөөр буюу 8.3 хувь, цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад үйл ажиллагааны зардлыг 230.0 сая төгрөгөөр буюу 28 хувиар хэмнэж ажилласан байна.

Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцахаар шийдвэрлэсний дагуу цахилгаан эрчим хүчний 1.1 сая хэрэглэгч, ДЭХ-ний 0.4 сая хэрэглэгч, давхардсан тоогоор 1.4 сая хэрэглэгчдийн нийт 814,700.0 сая төгрөгийг Монгол Улсын Засгийн газраас хариуцаж, өмнөх оны мөн үеийн хэрэглээ, ижил төстэй хэрэглэгчийн дундаж хэрэглээнээс илүү хэмжээгээр хэрэглэсэн 23,200.0 сая төгрөг буюу 17.2 хувийг хэрэглэгчид өөрсдөө хариуцсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 43, 2021 оны 207 дугаар тогтоолуудын холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 182.6 сая төгрөгийн хөрөнгөд хэсэгчилсэн тооллого хийхэд зөрчил илрээгүй болно. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар урамшууллын талаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг эрх зүйн үндэстэй гаргаж ирүүлэх үүрэг өгсөн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 66.6 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн биелэлт 66.6 хувь байгаа нь Эрчим хүчний сайдын 2021 оны А/92 тоот тушаалаар комисс томилон хамтын хэлэлцээрийг шинэчлэн батлахдаа өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тус салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх зорилготойгоор Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.8-д “Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл үр дүнд үндэслэн тухайн хамт олны /үйлдвэрийн цех хэлтэс, албадын/ албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно.” гэж заасны дагуу сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгож байгаагаас шалтгаалж байна.

Энэ хэлэлцээрийн 3.6-д жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохоор шийдвэрлэсэний дагуу 2.3 сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100
Зөвлөмж	3	13.4	2	13.4	1	-	66.6
Нийт дүн	4	13.4	3	13.4	1	-	83.3

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа он дамжсан авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг хянах;

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 12.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 14.1 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 95.9 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

Хамтын гэрээний 3.11 дэх заалтыг үндэслэн төрийн дээд шагнал, одон медалиар шагнагдсан ажилтнуудад 2.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. *“төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”* гэсэн заалттай нийцэхгүй”, *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны бүртгэл хөтлөлт холбоотой асуудал

Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгслийн сэлбэг шатахууны тооцоог хийхдээ нийт 27.5 сая төгрөгөөс 15.5 сая төгрөгийн сэлбэг, шатахууны бүртгэлийг хувийн хэрэгт хөтөлж, 12.0 сая төгрөгийн тооцоог холбогдох хувийн хэрэгт хөтлөөгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны “Маягт, заавар батлах тухай” 347 тоот тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашинуудын хувийн хэргүүдийг бүрэн хөтөлж, ойрын хугацаанд хянжуулж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрчим хүчний зохицуулах хороо	АХГ-2022/42/НА-СТА-ТӨА	Авто тээврийн хэрэгслийн сэлбэг шатахууны тооцоог хийхдээ нийт 27,515.3 мянган төгрөгөөс 15,533.9 мянган төгрөгийн сэлбэг, шатахууны бүртгэлийг хувийн хэрэгт хөтөлж, 11,981.3 мянган төгрөгийн тооцоог холбогдох хувийн хэрэгт хөтлөөгүй байна.	Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 заалтыг мөрдөж ажиллах;	1	11,981.3	-	-	-	-	-	-	-	-	1	11,981.3
2	Эрчим хүчний зохицуулах хороо	АХГ-2022/42/НА-СТА-ТӨА	Хуулиар мөнгөн шагнал олгодоггүй одон медалиар шагнагдсан ажилтнуудад мөнгөн урамшуулал олгож, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг мөрдөж ажиллах;	1	2,160.0	-	-	-	-	1	2,160.0	-	-	-	-
ДҮН					2	14,141.3	-	-	-	-	1	2,160.0	-	-	1	11,981.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 330/А.О.150458
АХГ-2022/42/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хамтын гэрээний 3.11 дэх заалтыг үндэслэн одон медалиар шагнуулсан ажилтнуудад 2,160,000.00 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 3.1.8 "Хорооны дарга нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах", Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.17 "Монгол Улсын төрийн дээд шагнал /Төрийн соёрхолт, гавьяат ажилтан, хөдөлмөрийн баатар/-аар шагнагдсан салбарын ажилтан, өндөр настанд тухайн ажиллаж байгаа болон харьяалагдах байгууллагаас Төрийн соёрхолт болон Гавьяат ажилтанг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин, Хөдөлмөрийн баатрыг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин үржүүлсэнтэй тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшууллыг тус тус олгоно.", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Салбарын хамтын хэлэлцээрт тусгаагүй төрийн дээд шагналыг хамтын гэрээнд тусгаж, мөнгөн урамшуулал олгохыг зогсоож, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Глейхан, нягтлан бодогч М.Мандах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГС НЯГТ ГУРАВ ХХК-ИЙН АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
З.ТУНГАЛАГ

0010800983

